

ГЛОБ ИНТЕРНЭШНЛ ТББ

# ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН МОНИТОРИНГ

Эмэгтэй улс төрч, эмэгтэй нэр дэвшигчдийн талаар ХМХ-р мэдээлсэн нь

2011 ОНЫ 11 САРЫН 23 УЛААНБААТАР ХОТ

## Гарчиг

1. Тайлангийн хураангуй.....	3
2. Мониторингийн үндэслэл.....	4
3. Мониторингийн зорилго, зорилт.....	4
4. Мониторингийн арга зүй.....	5
4.1 Мониторингийн хамрах хүрээ.....	5
4.2 Мониторингийн аргачлал.....	5
5. Мониторингийн үр дүн.....	7
5.1.1 Сонины үр дүн.....	7
5.1.2 Цахим хуудасны үр дүн.....	13
5.1.3 Google.mn үр дүн.....	18
6. Дүгнэлт.....	23

**Энэхүү хэвлэл мэдээллийн мониторингийг Их Британы элчин сайдын яамны санхүүжилтээр АНУ-ын Азийн Сан-гийн дэмжлэгтэйгээр Глоб Интернэшл ТББ-аас хэрэгжүүлж буй “УИХ-ын 2012 оны сонгуульд нэр дэвших эмэгтэйчүүдийг дэмжих нь” төслийн хүрээнд хийв.**

### **Тайлангийн хураангуй**

“2012 оны УИХ-н сонгуульд нэр дэвшигч эмэгтэйчүүдийг дэмжих нь” төслийн хүрээнд өргөн хэрэглээний сонин, цахим хуудсуудад эмэгтэй улс төрчид, эмэгтэй нэр дэвшигчид, шийдвэр гаргах түвшинд ажиллаж байгаа эмэгтэйчүүдийн талаар хэрхэн мэдээллэсэн байдлыг илрүүлэхээр Глоб Интернэшл ТББ-ын төслийн зохицуулагч Б.Онон, судлаач Д. Амарсайхан, Д. Мэндбаяр, Л.Анар, Д. Саруул нар 2008 оны 6-р сарын 21-27, 2011 оны 6-р сарын 13-19, 2011 оны 10-р сарын 12-25-ны өдрийг дуустал түргэвчилсэн мониторинг хийлээ.

Энэхүү тайлан нь мониторингийн үндэслэл, зорилго, зорилт, арга зүй, мониторингийн дүн, дүгнэлт гэсэн таван бүлгээс бүрдэнэ. Сонин болон цахим хуудаснаас мэдээлэл цуглуулсан маягтийг хавсаргасан болно.

Хэвлэл мэдээллийн түргэвчилсэн мониторингт өдөр тутмын “Өдрийн сонин”, “Өнөөдөр”, “Зууны мэдээ”, долоо хоног тутмын “Хүмүүс”, “Сэрүүлэг” сонингууд, [www.news.mn](http://www.news.mn), [www.olloo.mn](http://www.olloo.mn), [www.factnews.mn](http://www.factnews.mn), [www.caak.mn](http://www.caak.mn), [www.medee.mn](http://www.medee.mn), [www.amjilt.com](http://www.amjilt.com), [www.gogo.mn](http://www.gogo.mn), [www.shuud.mn](http://www.shuud.mn) болон [www.google.mn](http://www.google.mn) хайлтын системийг хамруулсан болно.

Ажиглагчид тусгайлан боловсруулсан түлхүүр асуулт бүхий тэмдэглэлт хүснэгтийн дагуу тоон болон чанарын мэдээлэл цуглуулж, Excel программд оруулж кодлон, SPSS 16.0 программаар боловсруулав.

Мөн Google хайлтын системээс “*эмэгтэй улс төрч, эмэгтэй нэр дэвшигч*” гэсэн түлхүүр үг ашиглан хайлтаар анх илэрсэн 2008 оноос 2011 оны 10-р сарын 25-ны өдрийг хүртэлх эхний 50-н мэдээлэлд дүн шинжилгээ хийлээ.

Мониторингийн хугацаанд 5 сонин, 8 цахим хуудас бүхий хэвлэл мэдээллийн хэрэгслээр эмэгтэй улс төрч, эмэгтэй нэр дэвшигчидтэй холбоотой 520 мэдээлэл гарсан байна. Үүний 287 буюу 55,1 хувь нь тодорхой нэр бүхий эмэгтэйчүүдийн тухай нийтлэсэн байв. Үүнээс 230 буюу 80,1 хувь нь интернэтээр, 57 буюу 19,8 хувь нь сонингоор дамжигдан цацагджээ.

Хэвлэл мэдээллийн хэрэгслүүдэд нийт 42 эмэгтэйтэй холбоотой мэдээлэл гарсан. Үүнээс одоогийн УИХ-н гишүүн С. Оюун, Д. Арвин, Д. Оюунхорол нартай холбоотой мэдээлэл нийт мэдээллийн 39,3 хувийг эзэлж байна. Тэр дундаа УИХ-ын гишүүн С. Оюунтай холбоотой мэдээлэл нийт мэдээллийн 22,3 хувиар хамгийн их жин дарж байгаа боловч түүнтэй холбоотой гарсан 66 мэдээллийн 18,2 хувь нь шууд буюу өөрөөс нь авсан, үлдсэн нь дурьдаад өнгөрсөн мэдээлэл байлаа.

5 сонин дахь эмэгтэйчүүдийн тухай бичвэр нийт 12,4 сонины нүүр талбайг эзэлж байна. 8 цахим хуудсан дахь мэдээлэл Times New Roman 9 фонтоор бичигдсэн 27,9 нүүр А4 хэмжээтэй материал гарсан байна.

Эмэгтэйчүүдтэй холбоотой мэдээллийн өнгө аясыг харахад нийт мэдээллийн 58 хувь нь төвийг сахисан байдлаар, 25 хувь эерэг байдлаар, 16,7 хувь сөрөг байдлаар нийтлэгджээ. Эмэгтэйчүүдтэй холбоотой мэдээллийн 84 хувь нь шууд бусаар үүнээс 5 дахин бага буюу 16 хувь нь шууд байдлаар бичигдсэн байв. Нэг үгээр хэлбэл эмэгтэй нэр дэвшигч, эмэгтэй улс төрчидтэй холбоотой таван мэдээлэл бүрийн дөрөв нь тэдний талаар дурьдаад өнгөрсөн, өөр эх сурвалжаас авсан мэдээлэл байна.

Өдөр тутмын сонинуудад төлбөргүй мэдээлэл, “Хүмүүс” сонинд төлбөртэй мэдээлэл жин дарж байна. Харин “Сэрүүлэг” сонины хувьд төлбөртэй, төлбөргүй мэдээлэл тэнцүү байлаа.

Төр, засгийн шийдвэр гаргах түвшинд ажиллах эмэгтэйчүүдийн хувьд боловсрол, хөрөнгө мөнгө, эмэгтэй хүнийг ялгаварлан үзэх нийгмийн хандлагаас болоод хэт өндөр шаардлага тавигддаг байна. Эмэгтэй хүн хүүхэд гэр бүлийн хүрээний хүн, сайн хань зэрэг эр хүний дэргэд байх туслагч гэсэн тогтсон хандлага хүчтэй байдаг. Тиймээс ч албан тушаал ахисан эмэгтэй хүнийг өөрийн чадлаараа гарч ирээгүй ямар нэр нам хүчин, нөлөө бүхий хүний туслалцаатайгаар гарч ирсэн гэх хандлага их байдаг.

Эрүүл мэнд, боловсрол, нийгмийн халамжийн салбарт эмэгтэй хүний халамжтай байдал дутагдаж байна, төр, засгийн шийдвэр гаргах түвшинд эмэгтэй хүн байх хэрэгтэй гэх боловч эрх

мэдэл албан тушаал хүсэгчид мэтээр үзэн жендерийн тэгш эрхийн асуудал квотын хүрээнээс хэтрэхгүй байна.

## **Нэг. Мониторингийн үндэслэл**

Монгол улс ардчиллын замыг сонгоод 21 жилийн нүүр үзээд байна. Энэ хугацаанд иргэд УИХ-ын гишүүдийг сонгох болон Ерөнхийлөгчийг сонгох сонгуулиудад оролцож, шийдвэр гаргах түвшиний хүмүүсийг сонгож ирсэн билээ. Өнөөдөр эргэн харахад өнгөрөгч таван удаагийн УИХ-ын сонгуулиар УИХ-ын гишүүн болон сонгогдож байсан эмэгтэй улс төрчдийн тоо аль ч сонгуулийн үеэр эрэгтэй улс төрчдийн тооноос илт цөөн байна.

Дэлхийн олон орон жендерийн тэгш эрх, тэгш байдлын хэмжээгээр тухайн орон дахь ардчилал хэр бодитой байгааг үнэлдэг. Тэгвэл дээрх жишээгээр манай оронд шийдвэр гаргах түвшинд жендерийн тэгш байдал учир дутагдалтай байгаа нь сөрөг нөлөө үзүүлж, ардчиллын үнэт зүйлс алдагдахад хүргэж байна. Энэ тэнцвэргүй байдалд олон хүчин зүйл нөлөөлөх нь дамжиггүй. Тэдний нэг нь өргөн цар хүрээтэйгээр сурталчилгаа, танин мэдэхүйн болон нөлөөллийн үүрэг гүйцэтгэж байгаа хэвлэл мэдээллийн хэрэгслээр цацагдаж байгаа мэдээлэл юм.

Иймээс хэвлэл мэдээллийн хэрэгслээр эмэгтэй нэр дэвшигчид, эмэгтэй улс төрчдийн талаарх мэдээлэлд мониторинг хийх шаардлагатай байна.

Глоб Интернэшнл ТББ АНУ-ын Азийн Сан-гийн дэмжлэгтэйгээр хэрэгжиж буй “УИХ-ын 2012 оны сонгуульд нэр дэвших эмэгтэйчүүдийг дэмжих нь” төслийн хүрээнд 2008 оны УИХ-ын сонгуульд нэр дэвшсэн эмэгтэйчүүд, эмэгтэй улс төрчдийн талаар сонин хэвлэл болон өргөн хэрэглээний цахим хуудсуудад гарсан мэдээлэл сурталчилгаанд мониторинг хийлээ.

## **Хоёр. Мониторингийн зорилго, зорилт**

2015 онд шийдвэр гаргах түвшний албан тушаалд эмэгтэй улс төрчдийн эзлэх хувь 30% хүрсэн байна гэсэн Мянганы хөгжлийн зорилтод чиглэн өнгөрөгч 2008 оноос хойш эмэгтэй нэр дэвшигчид болон улс төрчдийн талаар хэвлэл мэдээллийн хэрэгслээр гарсан мэдээ мэдээллийн ерөнхий дүр төрх, төр, засгийн шийдвэр гаргах түвшинд ажиллах эмэгтэй хүний талаар ямар санал бодол, ойлголт, төсөөлөл байгааг илрүүлэх зорилготой.

Энэхүү зорилгын хүрээнд дараах зорилтуудыг дэвшүүлж байна. Үүнд:

1. Эмэгтэй нэр дэвшигчийн талаарх мэдээллийн эзлэх хэмжээ, ач холбогдол өгсөн байдлыг (эрэгтэй нэр дэвшигчтэй харьцуулсан байдлаар, мэдээллийн хэрэгслийн аль хэсэгт гарснаар нь) үнэлэх
2. Тухайн нэр дэвшигчийн болон төр засгийн шийдвэр гаргах түвшинд ажиллах эмэгтэйчүүдийн талаарх үнэлэмж (1-ээс 5-н баллаар үнэлэн гаргах)
3. Эмэгтэй нэр дэвшигчийн талаарх мэдээлэл шууд болон шууд бус байдлаар нийтлэгдсэн, төлбөртэй эсэхийг илрүүлэх.
4. Төр, засгийн шийдвэр гаргах түвшинд ажиллах эмэгтэйд ямар байх ёстой, мөн яагаад эмэгтэй хүн тохирохгүй гэж үзэж байгааг тодруулах. (Мэдлэг боловсрол, нас, гадаад төрх, ажлын туршлага, зан чанар гэх мэт)

## Гурав. Мониторингийн арга зүй

### 3.1. Мониторингийн хамрах хүрээ

Уншигч захиалагчдын тоогоороо хамгийн их

- “Өдрийн сонин”
- “Өнөөдөр”
- ”Зууны мэдээ”
- “Хүмүүс”
- “Сэрүүлэг” гэсэн 5 сонин.

Хэвлэлийн хүрээлэнгийн 2008-2011 онд хийсэн судалгаагаар хамгийн олон хэрэглэгчидтэй

- [www.news.mn](http://www.news.mn)
- [www.olloo.mn](http://www.olloo.mn)
- [www.factnews.mn](http://www.factnews.mn)
- [www.caak.mn](http://www.caak.mn)
- [www.medee.mn](http://www.medee.mn)
- [www.amjilt.com](http://www.amjilt.com)
- [www.gogo.mn](http://www.gogo.mn)
- [www.shuud.mn](http://www.shuud.mn) гэсэн 8 цахим хуудас. [www.google.mn](http://www.google.mn) хайлтын систем хамрагдсан.

Хугацааны хувьд 2008 оны УИХ-ын сонгууль, 2011 оны 6-р сарын 15-ны өдөр Ерөнхийлөгчийн “Иргэний танхим”-д болсон УИХ-ын сонгуулийн тухай хууль-Жендерийн тэгш эрх сэдэвт хэлэлцүүлэг, 2011 оны 10 сард болсон Намрын чуулгантай холбогдуулан 3-н хэсэг хугацааг сонгон авсан. Үүнд:

- 2008 оны 6-р сарын 21-27-ны өдөр
- 2011 оны 6-р сарын 13-19-ны өдөр
- 2011 оны 10-р сарын 12-25-ны өдрийг дуустал хэмээн үзсэн.

### 3.2. Мониторингийн аргачилал

Урьдаас бэлтгэсэн түлхүүр асуулт бүхий тэмдэглэлт хүснэгтийн дагуу мэдээллийг бүрдүүлж, Excel программд оруулж кодлон, SPSS 16.0 программаар боловсруулав.

Мөн Google хайлтын системээс “эмэгтэй улс төрч, эмэгтэй нэр дэвшигч” гэсэн түлхүүр үг ашиглан хайлтаар анх илэрсэн 2008 оноос 2011 оны 10-р сарын 25-ны өдрийг хүртэлх эхний 50-н мэдээлэлд дүн шинжилгээ хийлээ. Google хайлтын системээс илэрсэн мэдээлэл дотор сонгосон цахим хуудсуудад байх мэдээлэл орсон бол давхцуулахгүйн тулд хасаж, эхний 50-н мэдээллийг сонгосон болно.

Мониторингийн маягтыг бөглөхдөө мэдээллийн хэмжээг см<sup>2</sup>-р хэмжсэн. Үүнд:

- Мэдээлэл нэг см<sup>2</sup>-н дотор байвал бүхэл 1 см<sup>2</sup> гэж тооцсон.
- Нэр дэвшигчийн зураг байвал текстээс тусад нь тооцсон.
- Нэр дэвшигч өөр нэр дэвшигчийн хамт, эсвэл намынхантайгаа хамт байвал зургийг том жижиг гэж үзэлгүй 1 см<sup>2</sup> гэж тооцсон.
- Харин нэр дэвшигч ганцаараа, эсвэл гэр бүлийнхэн, урлаг соёлын одод зэрэг улс төрөөс ангид хүмүүстэй хамт авахуулсан бол зургийг хэвлэгдсэн хэмжээгээр нь тооцов.

Нэр дэвшигчийн өнгө аясыг 1-5 гэсэн кодоор дүгнэв. Үүнд:

- 1 - Нэр дэвшигчийг хэт магтсан.
- 2 – Сайшааж, боломжийн хэмээн үзсэн.
- 3 – Төвийг сахисан.
- 4 – Муучилж, дарсан.
- 5 - Хэт муулж доромжилсон.

Шийдвэр гаргах түвшинд ажиллах эмэгтэй. 1-5 гэсэн код дүгнэв. Үүнд:

- 1- Төр, засгийн шийдвэр гаргах түвшинд эмэгтэй улс төрч зайлшгүй хэрэгтэй.

2- Төр, засгийн шийдвэр гаргах түвшинд эмэгтэй улс төрч тодорхой хэмжээгээр байх хэрэгтэй.

3- Төр, засгийн шийдвэр гаргах түвшинд эмэгтэй улс төрч байж ч болно байхгүй байж ч болно. Төдийлөн чухал биш.

4- Төр, засгийн шийдвэр гаргах түвшинд эмэгтэй улс төрч бараг хэрэггүй.

5- Төр, засгийн шийдвэр гаргах түвшинд эмэгтэй улс төрч огт хэрэггүй.


Сонины мэдээллийг дараах тохиолдолд төлбөрт мэдээлэл гэж үзэв. Үүнд:

- Төлбөртэй хэмээн тэмдэглэгдсэн
- Нэр дэвшигчийн мөрийн хөтөлбөр
- Намын лого тэмдэг бүхий материал
- Намын нэр, лого дэмжихийг уриалсан бичвэртэй зураг байвал
- Нэр дэвшигчийн зурагтай болон зураггүй реклам

## ДӨРӨВ. МОНИТОРИНГИЙН ҮР ДҮН


### 4.1. СОНИНЫ ҮР ДҮН

Улс төрчидтэй холбоотой мэдээллийн тоо




Улс төрчидтэй холбоотой мэдээлэл 7-10 хоног тутмын сонинуудад илүү нийтлэгдсэн байв. Энэ нь нийт мэдээллийн 60 хувийг эзэлж байна. Өдөр тутмын сонинуудаас “Зууны мэдээ” сонинд нийт мэдээллийн 21 хувь нь гарсан байна. Харин “Өдрийн сонин”-д хамгийн бага буюу нийт мэдээллийн 7 хувь нь нийтлэгджээ.

Нийт сонин дээр гарсан мэдээлэл (хувиар)




Сонин дээр хэвлэгдсэн улс төрчидтэй холбоотой мэдээллээс зөвхөн эрэгтэй улс төрчидтэй холбоотой мэдээлэл 73 хувь, зөвхөн эмэгтэй улс төрчидтэй холбоотой мэдээлэл эрэгтэйгээс 6,6 дахин бага буюу 11 хувь, харин эрэгтэй, эмэгтэй гэж хүйс ялгалгүй улс төрчдийн талаарх ерөнхий мэдээлэл 16 хувийг эзэлж байна.

Сонин тус бүрээр нь авч үзвэл (хувиар)



Сонин тус бүрээр нь авч үзвэл улс төрчидтэй холбоотой нийт мэдээллийн 4-9 хувь нь эмэгтэй улс төрчидтэй холбоотой мэдээлэл эзэлж байхад эрэгтэй улс төрчидтэй холбоотой мэдээлэл 51-82 хувийг эзэлж байна.


Хүйсээр нь авч үзвэл



Улс төрчидтэй холбоотой мэдээллийг хүйсээр нь авч үзвэл эрэгтэйчүүдтэй холбоотой мэдээлэл “Зууны мэдээ” сонинд, эмэгтэйчүүдтэй холбоотой мэдээлэл “Хүмүүс” сонинд хамгийн их гарсан байна.

“Өдрийн сонин”-д улс төрчидтэй холбоотой мэдээлэл хамгийн их гарсан боловч эмэгтэй улс төрчидтэй холбоотой мэдээлэл хамгийн бага гарсан байна. Харин “Хүмүүс” сонин дээр улс төрчидтэй холбоотой мэдээлэл хамгийн бага гарсан ч эмэгтэй улс төрчидтэй холбоотой мэдээлэл хамгийн их гарсан байлаа.

*Зөвхөн эмэгтэй улс төрчидтэй холбоотой мэдээлэл (хувиар)*




Мониторингт хамрагдсан таван сонины хувьд нийт 27 эмэгтэй улс төрчид, эмэгтэй нэр дэвшигчдийн нэрсийг дурьдсан 57 мэдээлэл нийтлэгдсэн байна. Дээрх 27 эмэгтэйчүүдээс УИХ-ын гишүүн С. Оюун, Б. Ундармаа нартай холбоотой мэдээлэл хамгийн их байлаа. Одоогийн эмэгтэй УИХ-ын гишүүдээс Д. Оюунхоролтой холбоотой нэг ч мэдээлэл сонгосон хугацаанд илэрсэнгүй.

*Тодорхой нэр бүхий эмэгтэйчүүдтэй холбоотой мэдээллийг гарсан хугацаагаар нь харвал*

*Өдөр тутмын сонинууд*



*Өдөр тутмын бус сонинууд*



Дээрх таван графикаас нийтэд нь харахад тодорхой нэр бүхий эмэгтэйчүүдтэй холбоотой гарсан мэдээллийн 77,1 хувь нь 2008 оны УИХ-ын сонгуулийн сурталчилгааны оргил үе болох сонгуулийн өмнөх долоо хоногт (6-р сарын 21-27-ны өдөр), 14 хувь нь 2011 онд болсон УИХ-ын сонгуулийн тухай хууль-Жендерийн тэгш эрх сэдэвт хэлэлцүүлгийн үеэр (6-р сарын 13-19-ны өдөр), 9 хувь нь 2011 оны Намрын чуулганы үеэр нийтлэгдсэн байна.

*Мэдээлэл сонины хэддүгээр нүүрэнд гарсан байдлыг сонин тус бүрээр харвал (хувиар)*

№	Сонины нэр	Сонины нүүр											
		1	2	3	4	5	6	7	8	9	10	11	19
1	Өдрийн сонин	0	25	0	0	0	25	0	0	0	0	0	25
2	Өнөөдөр	0	0	14	14	14	0	14	0	14	0	0	0
3	Зууны мэдээ	33	42	8	0	0	0	8	0	0	0	8	0
4	Хүмүүс	0	52,6	16	5	5	5	0	0	5	10,5	0	0
5	Сэрүүлэг	6,6	53	6,6	6,6	0	6,6	13	6,6	0	0	0	0


Нэр нь дурьдагдсан эмэгтэй улс төрчид, эмэгтэй нэр дэвшигчдийн талаарх мэдээлэл дээрх таван сонины хувьд 1- 3-р нүүрэнд түлхүү нийтлэгдсэн байв. Өдөр тутмын сонинуудаас “Зууны мэдээ” сонин 1, 2-р нүүрэндээ, 7-10 хоног тутмын “Хүмүүс”, “Сэрүүлэг” сонинууд 2-р нүүрэндээ хамгийн их мэдээлэл гаргаж, ач холбогдол өгчээ.

Мэдээллийн хэмжээ

Нэр нь дурьдагдсан болон дурьдагдаагүй нэр дэвшигчид, улс төрчдийн талаар нийт 164348 см<sup>2</sup> мэдээлэл гарчээ. Нэг сонины нүүрийг 1565 см<sup>2</sup> гэж үзвэл энэ нь 105 сонины нүүр материал болж байна. Үүний 87,1 хувь нь текс хэлбэрээр 12,8 хувь нь зураг хэлбэрээр нийтлэгдсэн байна.

Зөвхөн эрэгтэйчүүдтэй холбоотой мэдээлэл нийт мэдээлэл гарсан талбайн 70 хувийг, эмэгтэйчүүдтэй холбоотой мэдээлэл эрчүүдээс 5,9 дахин бага буюу 11,7 хувийг, тодорхой нэр дурьдаагүй ерөнхийд нь улс төрчдийн талаар гарсан мэдээлэл 18 хувийг эзэлж байв.

*Мэдээллийн талбайн хэмжээг сонин тус бүрээр харвал*




Сонин тус бүрээр нь үзвэл “Өдрийн сонин” 15,6 дахин, “Зууны мэдээ” сонин 7,8 дахин, “Өнөөдөр” сонин 4,9 дахин, “Хүмүүс” сонин 4,1 дахин, “Сэрүүлэг” сонин 3,9 дахин бага талбайд эмэгтэй нэр дэвшигч, эмэгтэй улс төрчидтэй холбоотой мэдээлэл нийтэлсэн байна.

Эрэгтэйчүүдтэй холбоотой текстэн мэдээлэл “Хүмүүс” сонинд, зураг “Зууны мэдээ” сонинд, эмэгтэйчүүдтэй холбоотой текстэн мэдээлэл “Сэрүүлэг” сонин, зураг “Хүмүүс” сонинд хамгийн их хэмжээгээр нийтлэгджээ. Аль ч хүйсийн хувьд 7 хоног тутмын Хүмүүс, Сэрүүлэг сонинуудад мэдээлэл их гарч харин “Өдрийн сонинд” хамгийн бага мэдээлэл гарсан байна.

Эмэгтэйчүүдийн талаарх өнгө аяс

Нийт сонинуудын тухайд 26 буюу 45,6 хувь нь төвийг сахисан байр сууринаас мэдээлжээ. 27 буюу 47,3 хувь нь эерэг, 4 буюу 7 хувь нь сөрөг хандлагатай мэдээлэл нийтлэгдсэн байна. Харин хэт муулж, доромжилсон мэдээлэл нийтлэгдээгүй байлаа.

*Эмэгтэйчүүдийн талаарх өнгө аясыг сонин бүрээр авч үзвэл*



“Өдрийн сонин”-гийн бүх мэдээлэл төвийг сахисан байдлаар бичигдсэн байсан. “Өнөөдөр”, “Хүмүүс сонинуудад мөн төвийг сахисан, “Зууны мэдээ”, “Сэрүүлэг” сонинуудад сайшааж, боломжийн хэмээн үзсэн мэдээлэл хамгийн өндөр хувьтай байна.

**Төр, засгийн шийдвэр гаргах түвшинд ажиллах эмэгтэйчүүдийн талаарх өнгө аяс**

Төр, засгийн шийдвэр гаргах түвшинд ажиллах эмэгтэйчүүдийн талаар 5 сонинд нийт 20-н мэдээлэл гарсан. Үүнээс 14 буюу 70 хувь нь эмэгтэй хүнийг шийдвэр гаргах түвшинд зайлшгүй хэрэгтэй, 5 буюу 25 хувь нь тодорхой хэмээжээгээр байх хэрэгтэй гэж үзжээ. Харин бараг хэрэггүй гэж 1 буюу 5 хувь нь үзсэн байв.


*Төр, засгийн шийдвэр гаргах түвшинд ажиллах эмэгтэйчүүдийн талаарх өнгө аясыг сонин тус бүрээр харьцуулан харуулбал*



Дээрх графикаас харахад эмэгтэйчүүд огт хэрэггүй, байж ч болно байхгүй байсан ч болно гэсэн сөрөг болон дундын байр суурь байхгүй байна. Бараг хэрэггүй гэж “Сэрүүлэг” сонины 1 мэдээлэл гарсан байсан. Ерөнхийдөө сонины хувьд эмэгтэйчүүдийг дэмжсэн байр суурьтай мэдээлэл цацагдсан байна.


**Шууд, шууд бус**

*Мэдээлэл шууд, шууд бус байдлаар нийтлэгдсэнийг сонин тус бүрээр харвал*



Нэр бүхий эмэгтэйчүүдтэй холбоотой мэдээллийн 72 хувь нь шууд бусаар буюу дам байдлаар, 28 хувь нь шууд буюу эмэгтэй нэр дэвшигч, эмэгтэй улс төрчийг эх сурвалжаа болгосон байв. Эмэгтэйчүүдтэй холбоотой нийт мэдээллийн 60 хувь нь нийтлэгдсэн “Хүмүүс”, “Сэрүүлэг” сонинуудад гарсан мэдээллийн 21 хувь нь шууд эх сурвалжтай мэдээлэл байна.

*Мэдээллийн төлбөртэй эсэх*



Эмэгтэй нэр дэвшигчид, эмэгтэй улс төрчидтэй холбоотой мэдээллийг төлбөртэй, болон төлбөргүй нийтлэгдсэн байдлаар нь үзэхэд “Өнөөдөр”, “Зууны мэдээ”, “Өдрийн сонин”-д төлбөргүй мэдээлэл, ”Хүмүүс” сонины тухайд төлбөрт мэдээлэл давамгайлсан байна. Харин “Сэрүүлэг” сонинын хувьд төлбөртэй, төлбөргүй мэдээлэл тэнцвэртэй байв.

№	Төр засгийн шийдвэр гаргах түвшинд ажиллах эмэгтэй ямар байх ёстой вэ?	Төр засгийн шийдвэр гаргах түвшинд яагаад эмэгтэйчүүд тохирохгүй вэ?
<b>"Өдрийн сонин"</b>		
1	Ж.Сүхбаатар ... Харин эмэгтэй түшээдийн шаардлага бодит амьдрал дээр байгаа гэдгийг <u>улс төрч эмэгтэйчүүд асуудалд шударга голчтой ханддагийг мэддэг</u> учраас ингэж хэлж байна"...	Би анх "Эмэгтэйчүүд манлайлал" санг байгуулахдаа л улс төр дэх эмэгтэйчүүдийн оролцоог дэмжиж ажиллана гэж зорьсон. Гэхдээ <u>эмэгтэйчүүд үнэхээр эвсэж чаддаггүй юм байна гэдгийг олон зүйл дээрээс харж байлаа.</u> ...
2	Цаг хугацаа өөрчлөгддөг, хүмүүс ч өөрчлөгддөг. <u>Улс төрийн нөхцөл байдал ч өөрчлөгддөг гэдгийг тооцоолох хаттай байх учиртай эмэгтэйчүүд.</u> Одоо байгаагаар бүх зүйлийг харах хэрэггүй гэж боддог ш дээ.	
<b>"Өнөөдөр" сонин</b>		
3	... Эрчүүд бол хатуу бодлогоор шийдвэр гаргадаг. <u>Эмэгтэй хүн илүү нарийн мэдрэмжтэйгээр асуудалд ханддаг. Энэ хоёр хандлага хоёулаа ижил хэмжээнд зэрэгцэн оршиж, нэг нь нөгөөгийнхөө дутууг гүйцээж, дундыг нь дүүргэнэ.</u>	
4	Монгол улсын ухаан дутаагүй, харин бусдыг хайрлах сэтгэл дутаж байна. <u>Монгол Улсын улс төрд эмэгтэйчүүдийн зөөлөн сэтгэл, хайр халамж дутаж байна.</u>	
<b>"Зууны мэдээ" сонин</b>		
5	<u>Шийдвэр гаргах түвшний эмэгтэйчүүд эрүүл мэнд, боловсрол, хүүхэд эмэгтэйчүүд гэр бүл зэрэг нийгмийн халамж хамгааллын асуудалд голлон анхаардаг.</u> Яагаад гэвэл эмэгтэй хүн үр хүүхдээ өсгөн хүмүүжүүлэх, хань нөхөрөө халамжлах гээд өрх гэрийнхээ бүх ачааг үүрч явдаг болохоор...	
<b>"Хүмүүс" сонин</b>		
6	<u>... гэр бүл, эмэгтэйчүүд хүүхэдгүй хандсан үйл ажиллагаа явуулдгаараа бусдаасаа онцлог юм.</u>	Эмэгтэйчүүдийн хүсэл мөрөөдөл өндөр болж. Улс орноо өөрчлөх юмсан, энэ авилгалжсан муухай, шударга бус байдаг, хүн ёсоор хөгжихгүй байгаа энэ байдлыг бид илүү шийдэж чадна гэсэн үзэл хандлага бий болсон байна. <u>Гэтэл тэднийг юү зогсоож байна вэ гэвэл "чи эмэгтэй" гэдэг хандлага.</u>
7	Т.Ганди бол нягт нямбай хашир улс төрч. Тэр тун эрхэмсэг харагддаг. Ажил амьдралын алия хошин үг хаялцаж хээ шаагүй байснаа, <u>төрийн чухал хэрэг ярилцах болоход төв түвшин ухаалаг голчтой санааг хэлэн тун хүндэтгэл төрүүлэм эрхэмсэг байдалтай харагддаг</u> юм билээ.	

**Төр засгийн шийдвэр гаргах түвшинд ажиллах эмэгтэй ямар байх ёстой вэ?**

- Шударга
- Нарийн мэдрэмжтэй
- Зөөлөн сэтгэл, халамжтай байх
- Сэтгэлийн хаттай байх

**Төр засгийн шийдвэр гаргах түвшинд яагаад эмэгтэйчүүд тохирохгүй вэ?**

- Эмэгтэйчүүд - Эвсэж чаддаггүй
- Нийгэмд –Эмэгтэйчүүд 2-рт гэсэн тэгш бус хандлага оршдог


## 4.2. ЦАХИМ ХУУДАСНЫ ҮР ДҮН

Цахим хуудаснуудын тухайд бидний сонгосон зарим нэг үеийн мэдээлэл архивлагдан хадгалагдаагүй байсан. Мөн сонгосон хугацааны зарим нэг өдөр, булангуудын мэдээлэл байхгүй байсан тул тухайн хугацаанд аль нэг буланд доод тал нь нэг мэдээлэл байгаа тохиолдолд хамрагдсан гэж үзэн шар дэвсгэрээр тодруулав. Цахим сайтууд дахь мэдээллийн тоог судалгаанд хамрагдсан хугацаатай харьцуулан үзүүлбэл

Цахим сайт дах мэдээллийн тоо, хугацаа

Цахим сайтууд	Хугацаа			Нийт
	2008.06.21-27	2011.06.13-19	2011.10.12-26	
	7 хоног	7 хоног	15 хоног	
www.news.mn		22	50	72
www.olloo.mn	35	8	21	64
www.factnews.mn	1	2	2	5
www.caak.mn	2	0	0	2
www.medee.mn		4	10	14
www.gogo.mn		1	11	12
www.amjilt.com		0	0	0
www.shuud.mn			13	13
<b>Нийт</b>	<b>38</b>	<b>37</b>	<b>107</b>	<b>182</b>



Цахим хуудсанд дээр гарсан мэдээллийг хувиар үзүүлбэл



Сонгогдсон найман сайтаас [www.olloo.mn](http://www.olloo.mn) хамгийн өргөн хүрээтэй хамрагдсан бол [www.amjilt.com](http://www.amjilt.com) бага хүрээтэй хамрагдаж нэг ч мэдээлэл олдсонгүй.

Харин мэдээллийн тоогоороо [www.news.mn](http://www.news.mn) 39 хувиар хамгийн их, дараагаар нь [www.olloo.mn](http://www.olloo.mn) 35 хувь, [www.medee.mn](http://www.medee.mn) 8 хувь, [www.gogo.mn](http://www.gogo.mn), [www.shuud.mn](http://www.shuud.mn) тус бүр 7 хувь, [www.factnews.mn](http://www.factnews.mn) 3 хувийг эзэлж хамгийн бага мэдээллийг [www.caak.mn](http://www.caak.mn) 1 хувь буюу энэ нь И. Нарантуяа, Г. Баасан нарын тухай гарсан ганц мэдээлэл байсан юм.

Цахим хуудсанд гарсан мэдээлэл (хувиар)




Сонгогдсон цахим сайтуудад нийт 27 улс төрч эмэгтэйчүүдийн талаарх мэдээлэл гарсан. Эдгээрээс С. Оюунтай холбоотой 51(28%), Т. Гандитай холбоотой 26(14,3%), Д. Арвинтай холбоотой 21(11,5%) мэдээлэл гарсан байна. Энэ гурван хүний мэдээлэл нийт мэдээллийн 53,8%-ийг эзэлж байна.

Эмэгтэйчүүдтэй холбоотой мэдээллийн 24 буюу 14 хувь нь нэр бүхий 10 эмэгтэйчүүдийн зурагтай мэдээлэл байсан.

Нийт 27 эмэгтэйгээс давхардсан байдлаар 24 нь [www.olloo.mn](http://www.olloo.mn) 17 нь [www.news.mn](http://www.news.mn) сайтанд гарсан байна. Д. Арвин, С. Оюун, Т. Гандигийн тухай тус бүр 7 цахим хуудсанд, Б. Долгорын тухай 5 цахим хуудсанд, Д. Оюунхоролын тухай 4 цахим хуудсанд буюу судалгаанд хамрагдсан 8 сайтын талаас илүүд нь энэ таван хүний тухай тавигдсан байна. Харин Ж. Занаа, Л. Эрдэнэчимэг, О. Ариунсан, Ч. Чимгээ, Х. Энхтуяа нарын тухай [www.olloo.mn](http://www.olloo.mn), Р. Бурмаа, С. Одонтуяа нарын тухай [www.news.mn](http://www.news.mn), И. Нарантуяагийн тухай [www.caak.mn](http://www.caak.mn) сайтанд нэг нэг удаа мэдээлэл нь тавигдсан байна.

Мэдээллийг шууд, шууд бусаар бичигдэснийг цахим хуудсаар нь харвал (хувиар)




Эндээс харахад нийт мэдээллийн 89 хувь нь шууд бусаар буюу эмэгтэйчүүдтэй холбоотой мэдээллийг өөрсдөөс нь аваагүй дам байдлаар, 11 хувь нь шууд буюу эмэгтэй нэр дэвшигч, эмэгтэй улс төрчийг эх сурвалжаа болгосон байлаа.

[www.factnews.mn](http://www.factnews.mn), [www.caak.mn](http://www.caak.mn), [www.medee.mn](http://www.medee.mn), [www.shuud.mn](http://www.shuud.mn) сайтуудын бүх мэдээлэл шууд бусаар бичигдсэн байв. Энэ нь шууд бусаар бичигдсэн мэдээллийн 19,7 хувийг эзэлж байна. Харин [www.news.mn](http://www.news.mn) дээрх таван мэдээлэл тутмын нэг нь, [www.gogo.mn](http://www.gogo.mn) дээрх зургаан мэдээлэл тутмын нэг нь шууд буюу тухайн хүнтэй ярилцаж авсан мэдээлэл байлаа.


Нийт цахим хуудсуудын тухайд 118 буюу 68,6 хувь нь төвийг сахисан байдлаар мэдээлсэн. 17 буюу 9,9 хувь нь эерэг, 37 буюу 21,6 хувь нь сөрөг хандлагатай мэдээлэл нийтлэгдсэн байна.

Эмэгтэйчүүдийн талаарх мэдээллийн өнгө аясыг цахим хуудас тус бүрээр харвал






[www.gogo.mn](http://www.gogo.mn), [www.news.mn](http://www.news.mn)-ны хувьд төвийг сахисан байдлаар илэрхийлсэн мэдээлэл жин дарж байсан ч дээрх гурван цахим хуудсуудын хувьд эерэг, сөрөг хандлагын аль алинаар нь харьцангуй тэнцвэртэй мэдээллэсэн байна.




[www.olloo.mn](http://www.olloo.mn), [www.factnews.mn](http://www.factnews.mn), [www.medee.mn](http://www.medee.mn) тухайд сөрөг мэдээлэл түлхүү нийтлэгдсэн байна. Харин [www.shuud.mn](http://www.shuud.mn) дээрх мэдээлэл бүгд төвийг сахисан байдлаар бичигдсэн байв.

*Төр, засгийн шийдвэр гаргах түвшинд ажиллах эмэгтэйчүүдийн талаарх хандлагыг цахим хуудас тус бүрээр харьцуулан харуулбал*



Төр, засгийн шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүд зайлшгүй хэрэгтэй гэж [www.news.mn](http://www.news.mn), [www.gogo.mn](http://www.gogo.mn)-ээр, тодорхой хэмжээгээр байх хэрэгтэй гэж [www.news.mn](http://www.news.mn), [www.olloo.mn](http://www.olloo.mn)-ээр, байж ч болно байхгүй байсан ч болно гэж [www.olloo.mn](http://www.olloo.mn)-ээр, бараг хэрэггүй, огт хэрэггүй гэж [www.news.mn-ээр](http://www.news.mn) дээрх хувиар цацагдсан байна.

#### Мэдээлэл гарсан булангууд



Улс төр, сонгууль, улс төрчид гэсэн булангуудад хамгийн их мэдээлэл тавигджээ.

Цахим хуудсуудад бичигдсэн зарим нэг эмэгтэй улс төрч, эмэгтэй нэр дэвшигчдийн талаарх ойлголт, тодорхойлолт, төсөөлөл

<a href="http://www.news.mn">www.news.mn</a>
<b>Мөн эмэгтэйчүүдийн хувьд боловсрох шаардлага байгааг энэ үеэр онцоллоо.</b>
“Өмнөх гурван авгайгаа яая гэж байхад дахиад арван авгай оруулж ирэх үү”
Гишүүн Ц.Батбаяр: -Ний нуугүй хэлэхэд одоогоор квотоор ярилцсан юм алга. Жендэрийг бол хүндэтгэнэ. Гэхдээ өнөөдөр УИХ-ын төвшинд л жендэрийн асуудал яригдаад байгаа болохоос биш бусад бүх төвшинд эмэгтэйчүүд давуу байгаа. Түүнийг харахгүйгээр хэдэн эмэгтэйчүүд “Бид УИХ-д заавал төлөөлөлтэй болох ёстой. Засгийн газарт төлөөлөлтэй болох ёстой” гээд байна л даа. Тэрнээс биш яам, агентлаг, хороо, дүүрэг, нийслэл гээд бүх газарт харин ч эмэгтэйчүүд 60 хувьд хүрчихээд байна. УИХ-ын сонгуульд заавал квотоор яах юм бэ.
<b>Эр хүн ямагт манлайлагч байсаар ирсэн. Үүнийг эмэгтэйчүүд ч хүлээн зөвшөөрдөг.</b> Тэр утгаараа өрх гэр хийгээд улс гүрнийг удирдан жолоодох үүрэг өдийг хүртэл эр хүний нуруун дээр явсаар ирсэн. Харин сүүлийн жилүүдэд эрчүүд өрх гэрийн тэргүүн гэх нэрнээс “огцрох” нь олшров. “Өрх толгойлсон эмэгтэй”-н тоо жилээс жилд өсч байгаа харамсалтай баримт байна.
Эршүүд чанар нь зөвхөн эр хүн хэмээх бодгаль дээр байдаггүй аж. Эр байх учиртай, ийм статустай байх ёстой чухал субъект бол төр. Төр төмөр нударгатай. Энэ бол харгислал гэсэн үг биш. Зүгээр л эршүүд чанарыг илэрхийлж буй хэрэг. Харин сүүлийн үеийн, ардчилал, даяаршлыг мэдэрсэн

Монголын төр хэт эх хүний, эмшсэн шийдвэрийг хэрэгжүүлж буй нь өдгөөгийн нийгмийг тэр чигээр нь эм-измд уруу татаж байгаа тухай судлаачид, эрдэмтэд хэлж байна. .... “Эмшсэн эртэй гэр-улсад ёс суртахууны уламжлал хийгээд хуулийн заалт тэр бүр хэрэгждэггүй” хэмээн доктор Ц.Түвшинтөгс гуай хэлсэн байна. Үнэн үг ажээ

... “Эмшсэн эртэй гэр-улсад ёс суртахууны уламжлал хийгээд хуулийн заалт тэр бүр хэрэгждэггүй” хэмээн доктор Ц.Түвшинтөгс гуай хэлсэн байна. Үнэн үг ажээ

Одоо хэдхэн сарын дараа болох сонгуулиар тэдний араас Их хуралд орохоор оочерлож байгаа хэдэн зуун хүн байна гээд бод доо. Нөгөөтэйгүүр, гаргасан шийдвэр нь яг л эх хүн үрээ тэжээж байгаа мэт. Шувуу өт хорхой амандаа зуун нисч үүрэндээ байгаа дэгдээхэйдээ аваачиж өгдөг. Эх шувуу нь шүү. Үүн шиг халамж, Хүний хөгжлийн мөнгө, Эх орны хишиг гэх мэт тоо томшгүй “өт хорхойг” иргэдийн аманд аваачиж чихсээр.

За гэвэл ёогүй байх эр хүний үндсэн философийг төр хэрэглэж гэмээнэ одоогийн энэ эмшсэн, нялцгай байдлыг халах цорын ганц зам болох ажээ.

[www.olloo.mn](http://www.olloo.mn)

Ар гэрээ авч явах ажил дээр эмэгтэйчүүд илүү. Тэгэхээр улс орныг эрчүүд нь удирдаад эмэгтэйчүүд нь тодорхой хэмжээнд туслалцаад, оролцох үедээ оролцоод явбал зүгээр байх.

Улс төрийн биеэ үнэлэгч

### 4.3. GOOGLE.MN ҮР ДҮН



Google хайлтын системээс “Эмэгтэй нэр дэвшигч”, “Эмэгтэй улс төрч” гэсэн хоёр түлхүүр үг ашиглан цахим хуудсан дээрх мэдээлэлтэй давхардаагүй байдлаар илэрсэн эхний 50 сэдвийг сонгон авч дүн шинжилгээ хийсэн.

*Хайлтаар илэрсэн мэдээллүүд хадгалагдаж байгаа цахим хуудсуудыг дурьдвал*

№	Цахим хуудас	№	Цахим хуудас
1	<a href="http://www.anji-uhaaral.blogspot.com">www.anji-uhaaral.blogspot.com</a>	25	<a href="http://www.news.gogo.mn">www.news.gogo.mn</a>
2	<a href="http://www.ardchilal.net">www.ardchilal.net</a>	26	<a href="http://www.olloo.mn">www.olloo.mn</a>
3	<a href="http://www.bidmongol.com">www.bidmongol.com</a>	27	<a href="http://www.open.parliament.mn">www.open.parliament.mn</a>
4	<a href="http://www.bolod.mn">www.bolod.mn</a>	28	<a href="http://www.origo.mn">www.origo.mn</a>
5	<a href="http://www.dailynews.mn">www.dailynews.mn</a>	29	<a href="http://www.news.niigem.mn">www.news.niigem.mn</a>
6	<a href="http://www.ebi.mn">www.ebi.mn</a>	30	<a href="http://www.pbatjargal.wordpress.com">www.pbatjargal.wordpress.com</a>
7	<a href="http://www.factnews.mn">www.factnews.mn</a>	31	<a href="http://www.politics.news.mn">www.politics.news.mn</a>
8	<a href="http://www.gender.gov.mn">www.gender.gov.mn</a>	32	<a href="http://www.president.mn">www.president.mn</a>
9	<a href="http://www.gonews.mn">www.gonews.mn</a>	33	<a href="http://www.sanal.mn">www.sanal.mn</a>
10	<a href="http://www.hi6.mn/blogs">www.hi6.mn/blogs</a>	34	<a href="http://www.sharsonin.mn">www.sharsonin.mn</a>
11	<a href="http://www.ichinnorov.mn">www.ichinnorov.mn</a>	35	<a href="http://www.sharmedee.com">www.sharmedee.com</a>
12	<a href="http://www.mminfo.mn">www.mminfo.mn</a>	36	<a href="http://www.shuum.mn">www.shuum.mn</a>
13	<a href="http://www.moenhbayar.blogspot.com">www.moenhbayar.blogspot.com</a>	37	<a href="http://www.songuuli.zindaa.mn">www.songuuli.zindaa.mn</a>
14	<a href="http://www.mones.org.mn">www.mones.org.mn</a>	38	<a href="http://www.tulhuur.com">www.tulhuur.com</a>
15	<a href="http://www.monfemnet.org">www.monfemnet.org</a>	39	<a href="http://www.mglradio.com">www.mglradio.com</a>
16	<a href="http://www.mongolian.mongolia.usembassy.gov">www.mongolian.mongolia.usembassy.gov</a>	40	<a href="http://www.bolod.mn">www.bolod.mn</a>
17	<a href="http://www.mongolnews.mn">www.mongolnews.mn</a>	41	<a href="http://www.inet.mn">www.inet.mn</a>
18	<a href="http://www.mobile.inet.mn">www.mobile.inet.mn</a>	42	<a href="http://www.tv5.mn">www.tv5.mn</a>
19	<a href="http://www.monkey.mn">www.monkey.mn</a>	43	<a href="http://www.vip76.mn">www.vip76.mn</a>
20	<a href="http://www.monsoc.blogspot.com">www.monsoc.blogspot.com</a>	44	<a href="http://www.webcache.googleusercontent.com">www.webcache.googleusercontent.com</a>
21	<a href="http://www.must-setgelsudlal.blogspot.com">www.must-setgelsudlal.blogspot.com</a>	45	<a href="http://www.yahoo.mn">www.yahoo.mn</a>
22	<a href="http://www.munhkbatt.blogmn.net">www.munhkbatt.blogmn.net</a>	46	<a href="http://www.yanaa.mn">www.yanaa.mn</a>
23	<a href="http://124.158.124.18/~ardchila/index.php?c=7">http://124.158.124.18/~ardchila/index.php?c=7</a>	47	<a href="http://www.zaluu.com">www.zaluu.com</a>
24	<a href="http://202.72.245.100/modules.php?name=News&amp;nID=1933">http://202.72.245.100/modules.php?name=News&amp;nID=1933</a>	48	<a href="http://www.news.now.mn">www.news.now.mn</a>

Дээрх 48 цахим хуудсанд дараах хүмүүсийн мэдээлэл доорх хувиар нийтлэгджээ

Зураг тоогоор




\* Бичвэрт тухайн хүний нэр дурьдагдаагүй боловч зураг нь нийтлэгдсэн мэдээ

Зарим мэдээ хоёроос дээш цахим хуудсанд нийтлэгдсэн байсныг тоо давхцуулахгүйн тулд нэгээр тооцож гаргасан. Тухайлбал “Шилдэг эмэгтэй улс төрч”-өөр Д. Оюунхорол шалгарлаа гэсэн мэдээлэл 10-н цахим хуудсан нийтлэгдсэн байв. Нийт 16 хүний зураг дээрх тоогоор тавигдсан байлаа.

Д. Арвин, С. Оюун, Д. Оюунхорол буюу одоогийн УИХ-ын гишүүдийн тухай 23 мэдээлэл буюу нийт гарсан мэдээллийн 29 хувийг эзэлж байна. Мөн нийт гарсан мэдээллийн 20


буюу 25 хувийг тодорхой нэр заагаагүй ерөнхийдөө дан эмэгтэй улс төрчдийн талаарх мэдээлэл нийтлэгджээ.

*Мэдээллийн нийтлэгдсэн хугацаагаар нь харвал*




Зарим цахим хуудсын тухайд тэр бүр мэдээллээ хадгалаад байдаггүй, хуучирсан мэдээллээ устгадагтай холбогдуулан хугацааны хувьд сонин, сонгосон цахим хуудсуудаас ялгаатай авч үзсэн. 2008 оны 1 сарын 1-ээс 2011 оны 10-р сарын 25 хүртэлх хугацаанд багтаж байвал тухайн мэдээллийг хамруулан сонгож авсан. Нийт мэдээллийн 41 хувийнх нь хугацааг тодорхойлох боломжгүй байсан. Хугацаа нь тодорхой мэдээллээс 2011 онд нийт мэдээллийн 29 хувь нь, 2010 онд 13 хувь нь, 2009 онд 6 хувь нь, 2008 онд 11 хувь нь нийтлэгдсэн байв.

*Мэдээлэл шууд эсэх*




Нэр нь дурьдагдсан 17 эмэгтэй улс төрч, эмэгтэй нэр дэвшигчдийн тухай мэдээллийн 79 хувь нь шууд бус, үүнээс 3,7 дахин бага буюу 21 хувь нь шууд мэдээлэл байлаа.

*Эмэгтэйчүүдийн талаарх өнгө аяс*



Нийт 58-н мэдээллээс 28 буюу 48 хувь нь тухай эмэгтэйд сайшааж боломжийн хэмээн үзсэн, 23 буюу 40 хувь нь төвийг сахьж илэрхийлсэн, 5 буюу 9 хувь нь муучилж, дарсан, 2 буюу 3 хувь нь тухайн хүнийг хэт муулж, доромжилсон өнгө аястай мэдээлэл байв. Харин хэт магтсан мэдээлэл байсангүй.

*Төр засгийн шийдвэр гаргах түвшинд ажиллах эмэгтэйчүүдийн талаарх үнэлэмж*



Төр засгийн шийдвэр гаргах түвшинд эмэгтэй хүн байх хэрэгтэй эсэх, хэр чухалчилж үзсэн байдлыг харахад нийт гарсан 47 мэдээллээс зайлшгүй хэрэгтэй гэж 33 хувь нь, тодорхой хэмжээгээр байх хэрэгтэй гэж 35 хувь нь, байж ч болно байхгүй байсан ч болно гэж 30 хувь нь, бараг хэрэггүй гэж 2 хувь нь үзсэн байна.

*Эмэгтэйчүүд, эмэгтэй улс төрчид, эмэгтэй нэр дэвшигчдийг үнэлж тодорхойлсон байдал*

1	Нийгмийн хамгийн хүнд ачааг нуруун дээрээ үүрч, өрх гэр, улс орныхоо төлөө өдөр шөнийг ялгалгүй зүтгэж яваа эмэгтэйчүүд ...
2	Ж. Сүхбаатар---одоо шийдвэр гаргах, улс төрд эмэгтэй гишүүдийн орон зай үгүйлэгдэж буй учраас дэмжих ёстой гэж үзэж байна”
3	М. Ичинноров---Ер нь ингэхэд над шиг ийм эрсдэлтэй бас зоригтой алхам хийсэн эмэгтэй улс төрч байна уу? \инээв\.
4	Эмэгтэй хүнийг хамгийн сайн нарийн бичиг, туслах, гүйцэтгэгч гэж харж дайчилж ажиллуулдаг. Тэгсэн мөртлөө хүмүүс нэг их удирдагч гэж хардаггүй . Ер нь эмэгтэй улс төрч төгс байх ёстой гэсэн шаардлага тавигдаад байдаг. Нам дотроос ч ийм шалгуур тавигддаг, гэр бүлээс ч тийм шалгуур тавигддаг.
5	Тавин сая, зуун сая төгрөгийг өөрийн хөрөнгөөс гаргаж өгөх эмэгтэй улс төрч тун ховор.
6	Эмэгтэйлэг гэхээсээ илүү эршүүд зан чанарыг нь онцлох хэрэгтэй болдог. Учир нь улс төрд хатуу бодлого явуулдаг эрэмгий хийгээд түрэмгий хүмүүс амжилтанд хүрдэг. Харин эмэгтэй улс төрчдийг эршүүд байхаасаа илүү эмэгтэйлэг байх ёстой гэж үздэг имижемейкерүүд байдаг. Энэ тохиолдолд амжилт олсон нь нэн ховор байдаг. Манай эмэгтэй улс төрчдийн хувьд энэ асуудал дээр маш их алддаг.
7	Улс төрийн PR-г хамгийн хэцүүд тооцогддог хүчин зүйл бол эмэгтэй улс төрчийн имижийг бүрдүүлэх явдал. Учир нь олон нийт эмэгтэйчүүдийг төр тэргүүлээд явах лидер гэсэн ойлголтоор биш улс төрчийн хань, сайхан ээж, гэрийн эзэгтэй гэсэн үүднээс асуудалд ханддаг. Энэ хандлага дорнын соёл иргэншилтэй орнуудад хүчтэй илэрдэг.
8	Нийгмийн шударга ёсыг тогтоох. Улс төрийг шударгаар явуулах,авлигагүй төрийн үйлчилгээг эмэгтэй улс төрч бүрдүүлнэ.
9	Хөөрхий миний ноён нуруутай, ААВ шиг зантай, эршүүд улс төрчид минь
10	Оюунгэрэл Ардчиллын төлөө 20 жил явсан, өндөр алба хашиж байсан, туршлагатай улстөрч.
11	Манайд эмэгтэй улс төрч хэн ч байсан түүнд "банзал авгай" гэдэг нэр гуншин зүүж өгнө. Үнэ цэнэтэй ямар ч эмэгтэй хүн байсан түүнийг янхан авгай хэмээн доромжлоно.
12	... төрийн өндөр албан тушаалтан хэдий ч хэтэрхий гэж хэлмээр энгийн эмэгтэй. Өөрийгөө дөвийлгөх гэсэн өчүүхэн ч хүсэлгүй ийм хүнтэй үнэндээ одоо үед цөөхөн тааралдана. Гаднаа эгэл даруу хэрнээ дотооддоо эрч хүчтэй эмэгтэй гэхээс өөрөөр түүнийг нэрлэмээргүй санагдсан.
13	Эмэгтэй хүн хэлж байгаа юм байна гээд үл тоох явдал нүүрэн дээр биш ч гэсэн далдуур зөндөө байдаг.
14	Эмэгтэй улс төрч хэзээ ч үзэл бодлоо мөнгөөр худалддаггүй шударга байж чаддаг. Авилга, хээл хахуульд өртдөггүй гээд сайн тал олон бий.

15	Хүй нэгдлийн үеэс л эрэгтэй, эмэгтэй хүний үүрэг өөр байсан. Эрчүүд ан агнаж, өрх бүлээ тэжээх үүрэгтэй байсан бол хүүхнүүд үр хүүхэд, настайчуудыг асарч, гэр орноо халамжилж байв. Энэ байдал генетикийн ойд хадгалагдан, одоо ч эмэгтэй хүний шинжийг илэрхийлдэг. Эрэгтэй хүн эмэгтэй хүний тусламжийг авах дургүй. Эмэгтэй улс төрч, эмэгтэй бизнесмени чадварт гэд эргэлздэг.
16	Эмэгтэй хүний уян сэтгэл, эр хүний байлдан дагуулах зан гээд бүгд цогцолж байж зөв шийдвэр гардаг гэж би ойлгодог.
17	Урьд нь сонгогдсон цөөн эмэгтэйчүүд хувийн гэхээсээ илүүтэй улс төрийн аль нэг нам хүчний рейтингийн фонноор л гарч ирж байгаа билээ.
18	Манай эмэгтэйчүүд шударга тул багийн тоглолт гэдэг хуйвалдаанд оролцохгүйгээр улс орны бодлогод нөлөөлж зөв болгоход хувь нэмрээ оруулж чадна.
19	... эмэгтэй улс төрчдийн аливаа асуудалд нягт нямбай ханддаг, зөвшилцөж чаддаг, боловсролын түвшин өндөр ...
20	Эмэгтэйчүүдээ ард түмэн голоод байна уу, эмэгтэйчүүд улс төрд хүчтэй гарч ирж чадахгүй байна уу? ----Улс төрд цойлон гарч ирэх ёстой байх гэж боддог. Хүний дэмжлэгээр бус өөрөө чадвартай байж, ард түмэндээ танигдаад гарч ирэх ёстой. Түүнээс жендер гээд заавал Сонгуулийн хуульд 30 хувийг тусгах шаардлагагүй байх. Өөрсдөө л сайн байж гарч ирэх ёстой.
21	Ер нь УИХ-ын сонгуулиар хангалттай эмэгтэй нэр дэвшигч байдаг шүү дээ. Намуудад 10-аад эмэгтэй нэр дэвшигч өрсөлддөг. Монголын ард түмэн эмэгтэй нэр дэвшигчиддээ өгөх хэрэгтэй. Түүнээс хэн нэгнээс буруутан хайх хэрэггүй байх. Хангалттай эмэгтэй гишүүд нэр дэвшдэг, түүнийг нь ард түмэн унагаад байдаг.
22	Монгол Ардын намын хорооны тэргүүлэгчдийн хурал дээр “Баян-Өлгий аймагт сонгууль мажротори системээр явагдана. Монгол Улсын Их хурлын 4, 5, 6 тойрог энэ аймагт байх болно. Манай аймгаас эмэгтэй нэр дэвшигч ялах магадлалгүй учраас намаас өгөх эмэгтэйчүүдийн квот хэрэггүй гэх мэт том том асуудлыг ярьцгаажээ.
23	Баян-Өлгий аймгийн нийт сонгогчдын 51 хувь нь эмэгтэйчүүд. Тэгээд ч Хамтарсан Засгийн газрын бүрэлдэхүүнд хоёр казак эмэгтэй дэд сайдаар ажиллаж, аймаг орон нутагтаа хандсан багагүй ажил хийж, нэр хүнд сайтай байгаа учраас эрхэм гишүүд ингэтлээ сандар ч байгаа бололтой.
24	НҮБ дахь АНУ-ийн өмнөх элчин сайд Жин Киркпатрик Эмэгтэйчүүд агуу сайн дурын гишүүн, кампанит ажлын менежер, хандив цуглуулагч, намын удирдагч, нэр дэвшигч, сонгогдсон удирдагч байж чаддаг.
25	Эмэгтэйчүүд өөрийн сонгогчидтой маш үр дүнтэй харилцан ажиллаж чаддаг, өөрийн үр хүүхдийнхээ ирээдүйн амьдралыг хамгаалах, дээшлүүлэх тал дээр үнэн сэтгэлээсээ ажиллаж чаддаг.
26	Эмэгтэйчүүд эдийн засаг, боловсролын түвшинг сайжруулах тал дээр цуцалтгүй тэмцэж чаддаг бөгөөд зөвшилцөөнд хүрэх, асуудлын шийдэл олох тал дээр маш чадварлаг.
27	Эмэгтэй нэр дэвшигчид маань бие биедээ дургүй гэдэг нь энэ сонгуулиар бүр тодорхой харагдлаа, тийм үү? -Тиймээ, хvvхнvvд маань угаасаа л бие биенээ дэмждэггүй шvv дээ. Би өөрийгөө энэ зовлонг хангалттай амссан хvний нэг гэж боддог. Эмэгтэйчvvд маань эмэгтэйчvvдээ дэмжихгvй болохоор төр засагт эмэгтэйчvvдийн төлөөлөл цөөхөн байгаа юм шvv дээ. Уг нь бие биеэ дэмжиж гар гараасаа хөглөлцөн нэг дуу хоолойтой байж чадвал бид их юмыг өөрчлөж чадах байсан. Би хэдэн жилийн өмнө яг ингэж боддог тэрийгээ вйл хэрэг болгохыг зорьдог байлаа. Гэтэл энэ бол романтик мөрөөдөл минь байжээ. Улстөрд хvсийн ялгаа гэж байдаггүй юм байна. Эмэгтэй хvнийхээ эсрэг эмэгтэй хvн ажиллана уу гэхээс эрэгтэй хvн ажилладаггүй юм байна. Vvнийг энэ сонгууль надад илvvтэйгээр ойлгуулж өглөө.
28	Цөхрөлтгүй тэмцэгч.
29	Заргач. Өөрийн намын гишүүдээ хүртэл шүүхэд өгч заргалдаж байсан. Тиймээс “Бурмаагийн явсан газар будлиантай”, “Бурмаа будлианы хутгуур” гэх мэт хэлц хэллэгүүдийг намынхан нь гаргажээ.
30	Хэдхэн улстөр хөөсөн амбицтай хүүхнүүд хийх ажлаа олж ядаад ийм асуудал босгож тавиад байгаа
31	... нийгмийн халамж, эрүүл мэндийн даатгалын тогтолцоо, эрүүл мэндийн үйлчилгээ, эмзэг бүлгийнхэнд туслах асуудлуудыг гярхай харах талаасаа эмэгтэйчүүд илүү.

## ТАВ. ДҮГНЭЛТ

1. Мониторингд хамрагдсан 5 сонин, 8 цахим хуудас бүхий хэвлэл мэдээллийн хэрэгслээр эмэгтэй улс төрч, эмэгтэй нэр дэвшигчидтэй холбоотой нийт 520 мэдээлэл гарснаас 287 буюу 55,1 хувь нь тодорхой нэр бүхий 42 эмэгтэйн тухай гарсан байв. Мониторингийн хугацаанд илэрсэн нийт мэдээллийн 59,9 хувь нь 8 цахим хуудсанд, 20,2 хувь нь [www.google.mn](http://www.google.mn) -ээс, 19,8 хувь нь сониноор цацагдсан байна.
2. Таван сонинд хэвлэгдсэн улс төрчидтэй холбоотой мэдээллийн 60 хувь нь өдөр тутмын бус “Хүмүүс”, “Сэрүүлэг” сонинуудад гарсан байв. Сонин дээр гарсан нийт мэдээллийн 11 хувь нь зөвхөн эмэгтэй улс төрчидтэй холбоотой мэдээлэл байгаагаас одоогийн УИХ-н гишүүн С.Оюун, Д.Арвин, Д.Оюунхорол нартай холбоотой мэдээлэл нийт мэдээллийн 39,3 хувийг эзэлж байна. Тэр дундаа С.Оюунтай холбоотой мэдээлэл нийт мэдээллийн 22,3 хувиар хамгийн их талбайг эзэлж байгаа боловч түүнтэй холбоотой гарсан 66 мэдээллийн 18,2 хувь нь шууд буюу өөрөөс нь авсан, үлдсэн нь дурьдаад өнгөрсөн мэдээлэл байлаа.
3. “Өдрийн сонин”-д улс төрчидтэй холбоотой мэдээлэл хамгийн их гарсан боловч эмэгтэй улс төрчидтэй холбоотой мэдээлэл хамгийн бага гарсан байна. Харин “Хүмүүс” сонин дээр улс төрчидтэй холбоотой мэдээлэл хамгийн бага гарсан ч эмэгтэй улс төрчидтэй холбоотой мэдээлэл хамгийн их гарсан байлаа.
4. Сонины хувьд сонгуулийн үеэр нийт мэдээллийн 77,1 хувь нь, УИХ-ын сонгуулийн тухай хууль-Жендерийн тэгш эрх сэдэвт хэлэлцүүлгийн үеэр 14 хувь нь, 2011 оны Намрын чуулганы үеэр 9 хувь нь хэвлэгджээ. Харин интернэтийн тухайд тэр бүр мэдээ, мэдээллээ хадгалаад байдаггүйтэй холбогдон хугацаа өнгөрөх тусам мэдээллийн тоо ихсэж байв.
5. Мэдээллийн хэмжээний хувьд сонины нэг нүүрийг 1565 см<sup>2</sup> гэж үзвэл нийт 105 хуудас сонины нүүр болсон. Үүний 87,1 хувь нь текст хэлбэрээр, 12,8 хувь нь зураг хэлбэрээр нийтлэгджээ. Нэр тодорхой нэр бүхий эмэгтэйчүүдийн тухай бичигдсэн 57 мэдээлэл 12,4 сонины нүүр талбайг эзэлж байна. Энэ нь дан эрчүүдтэй холбоотой мэдээллийн хэмжээнээс 5,9 дахин бага талбайд бичигдсэн байна. Хамгийн бага талбайг “Өдрийн сонин” 14,5 дахин бага зайд эмэгтэйчүүдийн талаарх мэдээлэл нийтэлсэн байв. Цахим хуудсан дахь мэдээлэл Times New Roman 9 фонтоор бичигдсэн 27,9 нүүр А4 хэмжээтэй материал гарсан байна.
6. Эмэгтэйчүүдтэй холбоотой мэдээллийн өнгө аясыг харахад нийт мэдээний 58 хувь нь төвийг сахисан байдлаар, 25 хувь эерэг байдлаар, 16,7 хувь сөрөг байдлаар нийтдлэгджээ. Google-ээс олдсон мэдээллүүдэд эерэг өнгө аяс давамгайлсан бол вэб сайтуудаас [www.olloo.mn](http://www.olloo.mn), [www.medee.mn](http://www.medee.mn), [www.factnews.mn](http://www.factnews.mn), дээрх мэдээллүүд сөрөг өнгө аястай цацагджээ. Сонины хувьд “Өдрийн сонин”-оос бусад нь эерэг мэдээлэл их бичсэн байв. Харин [www.shuud.mn](http://www.shuud.mn) болон “Өдрийн сонин ” дээр гарсан мэдээллүүд бүгд эмэгтэйчүүдийг магтаж, муулалгүй төвийг сахисан хандлагатай нийтлэгдсэн байлаа. Мөн 5 сонин хэт муулж доромжилсон мэдээлэл нийтлэгдээгүй байна.
7. Сонин болон интернетээр цацагдсан нэр бүхий эмэгтэйчүүдтэй холбоотой мэдээллийн 84 хувь нь шууд бусаар, 16 хувь нь шууд байдлаар бичигдсэн байна. Сонины хувьд мэдээллийнх нь 28 хувь нь, цахим хуудасны хувьд 11 хувь нь, google хайлтын системийн хувьд 21 хувь нь шууд байдлаар тус тус бичигдсэн байна. Эмэгтэй нэр дэвшигч, эмэгтэй улс төрчидтэй холбоотой таван мэдээлэл тутмын дөрөв нь тэдний талаар дурьдаад өнгөрсөн мэдээлэл байна.
8. Төр, засгийн шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүд зайлшгүй хэрэгтэй 41 хувь, тодорхой хэмжээгээр байх хэрэгтэй 36 хувь, байж ч болно байхгүй байсан ч болно 18 хувь, бараг хэрэггүй 4 хувь, огт хэрэггүй гэж 1 хувьтай байна. Эндээс үзвэл шийдвэр гаргах түвшинд эмэгтэй хүн үгүйлэгдэж байгаа нь харагдаж байна.

9. “Өнөөдөр”, “Зууны мэдээ” сонинуудад төлбөргүй мэдээлэл, ”Хүмүүс” сонины тухайд төлбөрт мэдээлэл давамгайлсан байна. Харин “Өдрийн сонин”, “Сэрүүлэг” сонинуудын тухайд төлбөртэй, төлбөргүй мэдээлэл тэнцвэртэй байдлаар нийтлэгджээ.
10. Төр, засгийн шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүд байх нь хэр чухал эсэхийг 1-5 баллаар үнэлэхэд 5 сонинд зайлшгүй хэрэгтэй, интернетээр цацагдсан мэдээллүүдэд тодорхой хэмжээгээр байх хэрэгтэй гэсэн мэдээлэл давамгайлсан байна. Нийтэд нь үзвэл нийт мэдээллийн 41 хувь нь зайлшгүй хэрэгтэй, 36 хувь нь тодорхой хэмжээгээр байх хэрэгтэй, 18 хувь нь байж ч болно байхгүй байсан ч болно, 4 хувь нь бараг хэрэггүй, 1 хувь нь огт хэрэггүй гэж үзжээ. Эндээс үзвэл шийдвэр гаргах түвшинд эмэгтэй хүн үгүйлэгдэж байгаа нь харагдаж байна.
11. Эмэгтэй нэр дэвшигч, эмэгтэй улс төрчдийн талаарх ойлголт, үнэлэмж, тодорхойлолт, төсөөлөл
- Төр засгийн шийдвэр гаргах түвшинд ажиллах эмэгтэй ямар байх ёстой вэ?
- Шударга
  - Нарийн мэдрэмжтэй
  - Зөөлөн сэтгэлтэй, халамжтай
  - Авлига хээл хахуулд автдаггүй
  - Аливаа асуудалд намбай ханддаг
  - Сэтгэлийн хаттай байх
  - Сайн боловсорч танигдах хэрэгтэй
  - Мөнгө, санхүүгийн боломжтой байх хэрэгтэй
- Төр засгийн шийдвэр гаргах түвшинд яагаад эмэгтэйчүүд тохирохгүй вэ?
- Эмэгтэйчүүд - Эвсэж чаддаггүй, эмэгтэйчүүдээ дэмждэггүй
  - Хангалттай боловсроогүй байдал
  - Нийгэмд –Эмэгтэйчүүд 2-рт, хүүхэд, гэр бүлийн хүрээний хүн, эрчүүдийн туслах гэсэн тэгш бус хандлага оршдог.